



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Г

Нийгмийн эрүүл мэндийн
хүрээлэнгийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 15, 16 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого”, Засгийн газрын “Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 27 дугаар тогтоол, “Төсвийн байгууллагад хийх бүтэц, зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” 2015 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн бүтцийг нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Шинэчлэгдэн батлагдсан бүтэц, дүрмийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Цогтбаатар/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 100 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД


Г.ШИЙЛЭГДАМБА



D:\barimt\tushaal

080935

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 07 сарын 21-йдрийн
27% дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 07.. сарын 21.. өдрийн
27.. дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн (цаашид “Хүрээлэн” гэх) нь хүний эрүүл мэнд, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн гүйцэтгэх эрүүл мэндийн байгууллага мөн.

1.2. Хүрээлэн нь эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа, бие даасан төрийн өмчит хуулийн этгээд байна.

1.3. Хүрээлэн нь Монгол улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.4. Хүрээлэн нь байгууллагын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, стратеги төлөвлөгөөнд сууриссан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна. Байгууллагын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө нь салбарын бодлого, яамны хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдсан байна.

1.5. Хүрээлэн нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, гудамж-17 гэсэн хаягтай байна.

1.6. Хүрээлэн нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

Хоёр. Хүрээлэнгийн үндсэн зорилго, чиг үүрэг

2.1. Хүрээлэнгийн эрхэм зорилго

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хэрэгжүүлэн нотолгоонд сууриссан бодлого боловсруулах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, НЭМ-ийн мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

2.2. Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Хүрээлэн нь Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дах заалт, Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 4, 11 дүгээр зүйлийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох;

2.2.2. Хүний эрүүл мэндэд нөлөөлж буй нийгэм, удамшил, орчны хүчин зүйлсийг тогтоох, үнэлэх чиглэлээр судалгаа хийх, тандалт явуулах,

судалгааны үр дүнг нийтэд сурталчлах, практикт нэвтрүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.2.3. Хүний билемахбод, эрүүл зүйн чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх;

2.2.4. Биотехнологийн вакцин биобэлдмэлийг турших, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх;

2.3. Хүрээлэнгийн үйл ажиллагааны зарчим:

- Хүрээлэн нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын нийтлэг үнэт зүйлс, зарчмыг үйл ажиллагаандaa удирдлага болгоно.
- Ейтууллагын ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.

Гурав. Хүрээлэнгийн эрх, үүрэг

3.1. Хүрээлэн нь дор дурдсан эрхтэй.

3.1.1. Өөрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн баримт бичиг боловсруулан мөрдүүлэх;

3.1.2. Чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг хууль, журмын дагуу захиран зарцуулах;

3.1.3. Ижил чиг үүрэг бүхий гадаадын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.1.4. Холбогдох асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил удирдах, нэг сэдээг бүтээл туурвих; эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шинжээчдийн дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулж санал өгөх;

3.1.5. Үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарыг бие даан болон хамтран зохион байгуулах;

3.1.6. Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг, гэрээ байгуулах;

3.1.7. Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн хүрээнд төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэх;

3.1.8. Хүрээлэн нь өөрийн байгууллагын шагнал, өргөмжлөл, тэмдэгтэй байх, шагнал урамшуулал олгох журмыг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн захирлын шийдвэрээр баталгаажуулах;

3.1.9. Байгууллагын ажилчдыг шагнах, шагналд тодорхойлж, холбогдох дээд шатны байгууллагуудад санал тавьж, шийдвэрлүүлэх;

3.1.10. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэд, үйлчлүүлэгчдэд өөрийн байгууллагын талаар болон нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааны чиглэлээр цахим хуудас, мэдээний сан зэргийг үүсгэх;

3.1.11. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, үр дүнг хэвлэх зорилгоор ном, гарын авлага, эмхэтгэл зэргийг эрхлэн гаргах, түгээх;

3.1.12. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

3.2. Хүрээлэн нь дор дурдсан үүрэгтэй.

3.2.1. Хүрээлэнгийн чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

- 3.2.2. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуурыг ханган ажиллах;
- 3.2.3. Байгууллага, иргэд, үйлчлүүлэгчдийг өөрийн үйл ажиллагаатай холбсойтой мэдээ, мэдээллээр хангах;
- 3.2.4. Нягтлан бodoх бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд явуулж, төсвийн санхүүжилтийн үр дүн, үр ашгийг тооцож, тайлгнах;
- 3.2.5. Байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;
- 3.2.6. Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллах;
- 3.2.7. Ажилтнуудынхаа нийгмийн баталгааг хангах, ажиллах дэмжлэгт орчин бүрдүүлэх талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;
- 3.2.8. Ажилтнуудынхаа мэдлэг үр чадварыг тасралтгүй дээшлүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, хэм хэмжээг мөрдүүлж ажиллах, сахилга, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- 3.2.9. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалтын бүтэц

- 4.1. Хүрээлэнгийн гүйцэтгэх удирдлагыг хүрээлэнгийн захирал хэрэгжүүлнэ.
 - 4.1.1. Захирал нь хүрээлэнгийн үндсэн чиг үүрэг, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө болон энэхүү дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
 - 4.1.2. Захирал өөрийн эрх, хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.
 - 4.1.3. Захирал нь холбогдох дээд шатны байгууллагатай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлтийг тайлгнана.
- 4.2. Хүрээлэнгийн дэргэд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын сэдэв, аргачлал батлах, явцыг хэлэлцэж, үнэлэлт, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Эрдмийн зөвлөл ажиллана.
 - 4.2.1. Эрдмийн зөвлөл нь докторын зэрэг бүхий 15 хүртэлх эрдэмтэн гишүүнтэй байна.
 - 4.2.2. Эрдмийн зөвлөлийн дарга нь Хүрээлэнгийн захирал, нарийн бичгийн дарга нь Эрдэмтэн нарийн бичгийн дарга байна.
 - 4.2.3. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Хүрээлэнгийн захирал батална.
- 4.3. Хүрээлэнгийн захирлын дэргэд байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад туслан зөвлөх үүрэг бүхий Удирдлагын зөвлөл ажиллана.
 - 4.3.1. Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд захирал ба нэгжийн дарга нар байна.

- 4.3.2. Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэх асуудлыг хүрээлэнгийн захирал, удирдлагын зөвлөлийн гишүүн санаачилна.
- 4.3.3. Удирдлагын зөвлөлийн хурлаас удирдлагын зөвлөлийн шийдвэр бүхий хурлын тэмдэглэл гарна.
- 4.4. Хүрээлэн энэ дурмийн 1.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийн даргыг холбогдох хууль, журмын дагуу Захирал томилж, чөлөөлнө.
- 4.5. Хүрээлэн нь ажилтнуудын нийгэм хамгаалал, эрх ашгийг хамгаалах, тэдний сурч боловсроход дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Үйлдвэрчний эвлэл"-тэй байж болно.

Тав. Хүрээлэнгийн нэгжийн чиг үүрэг

5.1. Хоол судлалын төв

Хүн амын хоол тэжээл, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, тухайн чиглэлээр холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хоол тэжээлээс шалтгаалсан эмгэгээс сэргийлэх талаарх сургалт, сурталчилгааг үндэсний түвшинд зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангана.

- 5.1.1. Хүнс, хоолны эрүүл ахуй, аюулгүй байдал, хүн амын хоол тэжээлтэй хамааралтай, түүний дотор шим тэжээлийн бодисын илүүдэл ба дутлын эмгэг, нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан, хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийн талаар эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажил гүйцэтгэх, хоол тэжээлийн зохисгүй хэрэглээ, таргалалт, эрсдэлт зан үйлсээс шалтгаалсан эмгэгээс сэргийлэх талаарх сургалт, сурталчилгааг зохион байгуулах;
- 5.1.2. Хүн амын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр тандалт судалгаа хийхэд бусад байгууллагатай хамтран ажиллах;
- 5.1.3. Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үеийн мэдээ, мэдээллээр хангах, мэдээний сан байгуулах;
- 5.1.4. Хоол судлалын чиглэлээрх төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, хоол хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн тандалт судалгаа болон хүн амын дундах хэрэглээний түвшнийг судлах судалгаа зохион байгуулах, оролцох, зөвлөмж боловсруулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах;
- 5.1.5. Эмчилгээний хоолны болон тусгай дэглэмийн хоолны жор, цэс боловсруулах үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, энэ чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах;
- 5.1.6. Хоол судлалын чиглэлээр олон улсын болон улс хоорондын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн яармагт оролцох, зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг сурталчлах, мэдээлэл, туршлага солилцох.

5.2. Орчны эрүүл мэнд, хор судлалын төв

Орчноос хүний эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс, хорт бодисын сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд зохион байгуулж мэргэжил, арга зүйгээр хангана.

- 5.2.1. Орчны эрүүл мэнд (агаар, хөрс, ус, хотжилт гэх мэт), хор судлал, цацраг идэвхит бодис, химиин бодисын хордлогын чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажил гүйцэтгэж шийдвэр гаргагчид, бодлого боловсрууллагчдыг нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээ, мэдээллээр хангах, судалгааны дүнг нийтэд сурталчлах;
- 5.2.2. Орчин болон хөдөлмөрийн эрүүл мэнд, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, стандарт журмын хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийх, энэ чиглэлээр бусад байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, хамтран ажиллах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- 5.2.3. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, уур амьсгалын өөрчлөлт, түүний хүний билемахбодид үзүүлэх нөлөөллийн талаар тандалт судалгаа хийх, мэдээ, мэдээллээр хангах, мэдээний сан байгуулах, бусад салбарын хамтын ажиллагааг уялдуулах, хамтран ажиллах, сургалт сурталчилгаа зохион байгуулах;
- 5.2.4. Хор судлал, химиин бодисын хордлогын чиглэлээр нийт хүн амын дунд тандалт судалгаа хийх, тандалт судалгааг зохион байгуулах, судалгааны мэдээний сан үүсгэх, баяжуулах;
- 5.2.5. Химиин бодис, эмгэг төрөгч бичил биетний хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх хорт бодисын зөвшөөрөгдөх хязгаар, норм нормативийг тогтоож, тодорхойлох шинжилгээний аргын стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах;
- 5.2.6. Химиин бодисын болзошгүй аюул, ослын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр бусад байгууллагаад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 5.2.7. Орчин, хөдөлмөрийн эрүүл мэнд, хор судлал, химиин бодисын хордлогын чиглэлээр олон улсын болон улс хоорондын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, яармагт оролцох, зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг сурталчлах, мэдээлэл, туршлага солилцох.
- 5.3. Эрүүл мэндийг дэмжих, сургалт, судалгааны арга зүйн төв
- Хүн амын эсүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг судлах, тандах, эрүүл мэндийн дэмжлэгт орчин бүрдүүлэх, судалгааны арга зүй, тархвар зүйн чадавхийг сайжруулах чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж, хууль, тогтоомж, бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрсдэлт зан үйлсээс шалтгаалсан эмгэгээс сэргийлэх талаарх үйл ажиллагааг үндэсний түвшинд зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангана.
- 5.3.1. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, стратеги, хөтөлбөрүүдийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн тайланг нэгтгэх;
- 5.3.2. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг үндэсний түвшинд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 5.3.3. Эрүүл мэндийг дэмжигч орчныг бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагаудын оролцоог хангах.

- 5.3.4. Монгол хүний өвөрмөц онцлогт тохирсон зан үйлийн хэв маягийг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж гүйцэтгэн судалгааны дүнг нийтэд сурталчлах;
- 5.3.5. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгааны мэдээний сан үүсгэж баяжуулах;
- 5.3.6. НЭМ-ийн сургалт удирдан зохион байгуулах, багшлах чадавхитай үндэсний боловсон хүчнийг бий болгох;
- 5.3.7. НЭМ-ийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах урт ба богино хугацааны сургалтыг төлөвлөх, зохион байгуулах, сургалтын хэрэгцээ ба үр дүнг тогтмол үнэлэн цаашдын үйл ажиллагаандaa тусгаж ажиллах;
- 5.3.8. Өвчин ба эрсдэлт хүчин зүйлсийн тархалт тогтоох тархвар зүйн болон хүн амын дундах эрсдэлт зан үйлийг судлан тогтоох чанарын судалгааны арга зүй, чадвар эзэмшигүүлэх сургалт зохион байгуулах;
- 5.3.9. Судалгааны ерөнхий арга зүй, судалгааны тоон үр дүнд статистик боловсруулалт хийх чадвар эзэмшигүүлэх сургалт зохион байгуулах;
- 5.3.10. Эрүүл мэндийг дэмжих, чадавхи бэхжүүлэх, судалгааны арга зүй, тархвар зүйн чиглэлээр олон улсын болон улс хоорондын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, яармагт оролцох, зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг сурталчлах, мэдээлэл, туршлага солилцох.

5.4. Хүн амын генетик, биотехнологийн үйлдвэр, судалгааны төв

Хүн амын өвчлөл, нас баарлгад байгаль цаг уур, газар зүй, удмын сангийн хүчин зүйлсийг судлах, анагаах ухааны биотехнологийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үндэсний түвшинд зохион байгуулах, хийж гүйцэтгэх, биотехнологийн вакцин, биобэлдмэлийг үйлдвэрлэх, ханган нийлүүлэх ажлыг хариуцан ажиллана.

- 5.4.1. Хүн амын генетик, экологийн эрүүл мэнд судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж гүйцэтгэх, судалгааны дүнг нийтэд сурталчлах;
- 5.4.2. Монголын хүн амын өвчлөл, нас баарлтын газар зүйн атлас боловсруулж, хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй бусад хүчин зүйлсийн шүтэлцээг тогтоох;
- 5.4.3. Хүн амын эрүүл мэнд, удмын сангийн аюулгүй байдлын чиглэлээр бодлогын түвшинд нотолгоогоор хангах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэх, судлаач солилцох, суралцуулах;
- 5.4.4. Анагаахын биотехнологи, нанотехнологийн чиглэлээр суурь судалгаа, цөм технологи, инновацийн төсөлт ажлыг үндэсний түвшинд зохион байгуулах;
- 5.4.5. Вакцин, биобэлдмэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний шинэ загвар боловсруулах, өнөөгийн технологийг сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх, биотехнологийн шинэ бүтээгдэхүүн, инновацийг туршиж үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- 5.4.6. Биоаюулгүйн асуудлаар судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан бодлогын санал, зөвлөмж боловсруулах, мэдээ, мэдээллээр хангах;

- 5.4.7. Полиомиелитийн, молекул биологийн, биотехнологи, инновацийн туршилтын лабораторийн үйл ажиллагаа эрхлэх;
- 5.4.8. Урьдчилан сэргийлэх вакцин, оношуулур, тэжээлт орчин, антибиотикийн диск, цусны уурагт бэлдмэл гэх мэт дархлаажуулалтын болон эмчилгээ оношлогооны чиглэлээр биобэлдмэл үйлдвэрлэнэ.
- 5.4.9. Хүн амын генетик, экологийн эрүүл мэнд, биотехнологийн чиглэлээр олон улсын болон улс хоорондын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн яармагт оролцох, зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг сурталчлах, мэдээлэл, туршлага солилцож, ажиллах.

5.5. Нийгмийн эрүүл мэндийн лавлагаа төв

Нийгмийн эрүүл мэнд болон лабораторийн чиглэлээр лавлагаа төвийн үүрэг гүйцэтгэж, нийгмийн эрүүл мэндийн тандалт судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, мэдээний нэгдсэн сан байгуулах, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үндэсний түвшинд хор, хордлого, шим тэжээлийн лабораторийн чиглэлээр лавлагаа үйлчилгээ үзүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

5.5.1. Нийгмийн эрүүл мэндийн тандалт, мэдээллийн алба

- 5.5.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд шаардлагатай баримт, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн, нотолгоонд суурилсан мэдээллээр бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэглэгчдийг хангах;
- 5.5.1.2. Нийгмийн эрүүл мэнд ба эрүүл мэндийн судалгааны чиглэлээр үндэсний түвшний мэдээний сан үүсгэж, тандалтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах;
- 5.5.1.3. Халдварт бус өвчний чиглэлээр хүн амд суурилсан тандалт, бүртгэлийн тогтолцоог чадавхжуулахад үндэсний түвшинд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 5.5.1.4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, осол, гамшигийн үед бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангах.

5.5.2. Шим тэжээлийн лаборатори

- 5.5.2.1. Хоол хүнсний шимт, тэжээллэг чанарыг тодорхойлох, лабораторийн шинжилгээ хийх;
- 5.5.2.2. Хоол хүнсний шим тэжээлийн хүний эрүүл мэнд, удмын сан, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх;
- 5.5.2.3. Хоол хүнсний шим тэжээл болон орчны эүүл мэндийн асуудлаар үндэсний түвшинд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 5.5.2.4. Хоол хүнсний шим тэжээл, технологи, хэрэглээ, үйлчилгээний чиглэлээр лабораторийн сургалт, сурталчилгаа явуулах;
- 5.5.2.5. Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамрагдаж, дотооддоо магадлан итгэмжлэгдсэн байна.

5.5.3. Хор судлалын лаборатори

- 5.5.3.1. Химиин болон эмнэлзүйн хор илрүүлэх, лабораторийн шинжилгээ хийх;

- 5.5.3.2. Химийн бодисын хүний эрүүл мэнд, удмын сан, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийн талаар тандалт судалгаа хийж, мэдээний сан бүрдүүлэх;
- 5.5.3.3. Үндэсний түвшинд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 5.5.3.4. Хор судлалын чиглэлээр лабораторийн сургалт, сурталчилгаа явуулах;
- 5.5.3.5. Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамрагдаж, дотооддоо магадлан итгэмжлэгдсэн байна.

5.6. НЭМ-ийн бодлого зохицуулалт, хөгжлийн алба

- 5.6.1. Нийгмийн эрүүл мэндийн талаар хэрэгжүүлэх хөтөлбөр, стратеги, стандарт болон дагалдан гарах баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулах үндэслэл, бодлогын санал, зөвлөмж боловсруулах;
- 5.6.2. Үндэсний хэмжээнд НЭМ-ийн төвүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, дэмжиж, чиглүүлж ажиллах;
- 5.6.3. Хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх, байгууллагад хэрэгжиж буй төслийн хэрэгжилтийг зохицуулах;
- 5.6.4. Хүрээлэнгийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 5.6.5. Байгууллагын хөгжил, хүний нөөцийн хөгжил, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 5.6.6. Хүрээлэнгийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр нэгжийн удирдлага, ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлно.
- 5.6.7. Нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;
- 5.6.8. Хүрээлэнгийн удирдлагын шийдвэр гаргахад эрх зүйн дэмжлэг үзүүлэх;
- 5.6.9. Албан хэрэг хөтлөлт, албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих;

5.7. Санхүү, аж ахуйн алба

- 5.7.1. Хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг явуулах дэмжлэгт орчин бүрдүүлэх;
- 5.7.2. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг бүрдүүлэн ажиллах;
- 5.7.3. Хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг хууль, дүрэм, журмын дагуу явуулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг тооцох;
- 5.7.4. Нэгжүүдийн дотоод нөөц, боломжкоо ашиглан орлого олох үйл ажиллагааг төлөвлөх, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих;
- 5.7.5. Байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, бүртгэлийг хариуцаж, хөрөнгийн зүй зохистой харьцаа, үр өгөөжийг дээшлүүлэн санхүүгийн тогтвортой ажиллагааг хангах
- 5.7.6. Байгууллагын санхүү, эдийн засаг, төсвийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулж, түүнд хяналт тавих;
- 5.7.7. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулах;
- 5.7.8. Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх, бүртгэх, тайлагнах;

Зургаа. Хүрээлэнгийн гадаад, дотоод хамтын ажиллагаа

6.1. Хүрээлэн нь өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд холбогдох яам, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

6.2. Хууль, журмын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ, хэлцэл байгуулан баталгаажуулан ажиллаж болно. Гэрээ хэлцэл хийх эрхийг Хүрээлэнгийн захирал хэрэгжүүлнэ.

6.3. Гадаадын ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах, байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, зочид, төлөөлөгч урих, үндсэн чиг үүргийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр харилцаагаа хөгжүүлэн ажиллана.

6.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэрээнд байгууллагаа төлөөлж гарын үсэг зурах эрхийг Хүрээлэнгийн захирал эдлэнэ.

6.5. Хүрээлэнгийн захирлын гадаад, дотоод томилолтыг Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, хүрээлэнгийн бусад ажилтнуудын гадаад, дотоод томилолтын асуудлыг Захирлын холбогдох шийдвэрээр баталгаажуулна.

Долоо. Хүрээлэнгийн санхүүжилт

Хүрээлэнгийн үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- 7.1. Улсын төсөөв;
- 7.2. Үйл ажиллагаанаас олсон орлого
- 7.3. Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр;
- 7.4. Хууль, тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Найм. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Удирдлагын зөвлөлийн саналыг үндэслэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Эрүүл мэнд, спортын сайдад уламжилж шийдвэрлүүлнэ.